Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### **3.4. Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үйл ажиллагааны зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны үр дүн 28,274,809.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 282,748.1 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,254,748.9 мянган төгрөгөөр буюу 11.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө 1,122,948.5 мянган төгрөг, авлага 1,975,304.0 мянга, өр төлбөр 1,331,268.5 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	1,122,948.5	1,122,948.5
Авлага	885.4	1,976,189.4	1,975,304.0
Урьдчилгаа	112,269.6	1,063,656.0	951,386.4
Бараа материал	5,150,135.9	2,890,105.9	-2,260,030.0
Үндсэн хөрөнгө	5,253,508.3	4,718,648.3	-534,860.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>10,516,799.2</b>	<b>11,771,548.1</b>	<b>1,254,748.9</b>
Өр төлбөр	0.0	1,331,268.5	1,331,268.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	10,516,799.2	10,440,279.6	-76,519.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>10,516,799.2</b>	<b>11,771,548.1</b>	<b>1,254,748.9</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,122,948.5 мянган төгрөгөөр өссөн нь “COVID-19” вирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор Шадар сайдын 2020 оны 23 дугаар тушаалын дагуу гадаад улс орнуудаас ирж байгаа иргэдийг түр тусгаарлах байранд байрлуулах ор хоногийн төлбөрийг Хаан банкны 5084538375 тоот дансанд төвлөрүүлж, иргэд аж ахуйн нэгж байгууллагуудаас хандивласан мөнгөн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 1,976,189.4 мянган төгрөг болж 1,975,304.0 мянган төгрөгөөр өссөн нь ЗГ-ын 2020 оны 240 дүгээр тогтоолын зарцуулагдаагүй 815,312.4 мянган төгрөг, хандивын 1,131,317.0 мянган төгрөгийн орлогыг тус тус тайлант хугацааны эцэст Сангийн яаманд татан төвлөрүүлснээр авлага нэмэгдсэн байна.

Урьдчилж гарсан зардлын дансны тайлант хугацааны эцсийн үлдэгдэлд Онцгой байдлын албаны хувцас бэлтгэхэд зарцуулсан 614,500.0 мянган төгрөг, гэнэтийн осол болон тээврийн хэрэгсэл, жолооч нарын даатгалын зардлыг хорогдуулан бүртгэсэн 320,923.0 мянга, засварын ажлын урьдчилгаанд төлсөн 76,796.2 мянга, санхүүгийн түрээсийн гэрээгээр Hyundai Sonata DNB /шуурхай алба/-ны автомашиныг худалдан авахад 51,436.8 мянган төгрөг тус тус байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,890,105.9 мянган төгрөг болж 2,260,030 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 8,196,907.3 мянган төгрөгийг бусад салбар нэгжүүдэд шилжүүлэн олгосноос шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,718,648.3 мянган төгрөг болж 534,860.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийг хуримтлуулан бүртгэснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 489,184.0 мянган төгрөг, хандив болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 306,435.2 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 270,000.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,331,268.5 мянган төгрөгөөр өссөн нь коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор тусгаарлах байруудаар үйлчилж байгаа иргэдийн ор хоногийн төлбөр 1,144,348.5 мянган төгрөг, Ди Би Эм Лизинг ХХК-д төлөх автобусны 183,814.5 мянган төгрөг, бусад 3,105.5 мянган төгрөгийг өглөгийг тусгаснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,440,279.6 мянган төгрөг болж 76,519.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ.

Тайлант хугацааны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 12,608,114.4 мянган төгрөгөөр буюу 39.8 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 15,801,692.1 мянган төгрөгөөр буюу 55.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан COVID-19 цар тахалтай холбоотой Засгийн газрын тогтоолуудын дагуу гарсан зарцуулалтууд байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 30,166,465.8 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 3,136,815.1 мянган төгрөгөөр бууруулж 27,029,650.7 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь их засвар, хөрөнгө оруулалтын зардлуудыг бууруулж баталсантай холбоотой байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 27,029,650.7 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 27,022,146.9 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд зарцуулж 7,503.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 99.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 1,357.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3,046.3 мянга, хангамж бараа материалын зардлыг 231.2 мянга, нормативт зардлыг 16.9 мянга, эд хогшил худалдан авах зардлыг 39.2 мянга, томилот, зочны зардлыг 307.1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 2,347.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 13.3 мянга, урсгал шилжүүлгийн зардлыг 144.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээ 7,503.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулж хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 4,342,661.6 мянган төгрөг, гадаад төсөл хөтөлбөрөөс 338,071.7 мянга, Засгийн газрын нөөц сангаас 10,967,140.9 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,561,001.9 мянга, нийт 17,208,876.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Засгийн газрын тогтоолуудаар 10,151,828.4 мянган төгрөг, нөөцийн барааны бүрдүүлэлт болон хувцас хэрэгсэлд 1,542,573.6 мянга, COVID-19 цар тахлын зарцуулалтад 3,924,344.7 мянга, нийт 15,618,746.7 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 1,590,129.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 173 мэдээллээс хугацаандаа оруулсан 75 мэдээлэл, хугацаа хоцроосон 92 мэдээлэл, 6 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 184,691.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг биелүүлж, 52,674.3 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	2	184,691.0	2	184,691.0	-	0.0	0.0
Зөвлөмж	4	52,674.3	3	52,674.3	1	0.0	0.0
Нийт дүн	6	237,365.3	5	237,365.3	-	0.0	0.0

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,212,691.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 320,052.2 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 892,639.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 320,052.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч албан шаардлага хүргүүлж, шилэн данстай холбоотой хуулийн хэрэгжилтийг хангуулаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацаанд оруулбал зохих 173 мэдээллээс хугацаандаа оруулсан 75 мэдээлэл, хугацаа хоцроосон 92 мэдээлэл, 6 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан хүлээнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

2. ОБЕГ "Монгол Хьюндай автоматив" ХХК-тай 92,000.0 мянган төгрөгийн санхүүгийн түрээсийн гэрээ байгуулж, Hyundai Sonata DNB /шуурхай алба/-ны автомашиныг холбогдох газрын зөвшөөрөлгүй худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7 "төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа,

болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3. Тайлант хугацаанд ОБЕГ Монголын улаан загалмай нийгэмлэгтэй хамтран ажиллах сургалт зохион байгуулах нэмэлт гэрээ байгуулсан байна. Гэвч дээрх байгууллага сургалт зохион байгуулаагүй байхад тус байгууллагад 50,000.0 мянган төгрөгийг шилжүүлж бусдаар гүйцэтгүүлэх арга хэмжээний зардлаар бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

4. Шадар сайдын 2020 оны 37, 54, 65, 73 дугаар тушаалаар нийт 178,052.2 мянган төгрөгийн зардлыг батлагдсан төсвийн багцаас санхүүжүүлэхээр заасныг зөрчин байгууллага, иргэдийн хандивын хөрөнгөөс зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

5. Урьд оны санхүүгийн тайлангийн аудитаар ОБЕГ-ын аппаратын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 892,639.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

Онцгой байдлын ерөнхий газар тайлант онд нийт 48,934.1 мянган төгрөгийн засварын ажлын гэрээг дүгнэж, акт үйлдээгүй байгаа нь гэрээгээр гүйцэтгэж байгаа ажлын хяналтыг бууруулж, хариуцлагыг сулруулж байгаа нь анхаарал татахуйц асуудал байна.

Нягтлан бодогч нарын ажлын ачаалал жигд бус, ажлын хариуцлага сул, хариуцсан ажлаа бүрэн гүйцэтгэж чадахгүй байгаа зэрэг байдал нь аудитыг гүйцэтгэхэд цаг хугацаа их шаардагдах, хүндрэл бэрхшээлтэй байв.

Ковид-19 цар тахлын улмаас бүх нийтийн бэлэн байдал зарласантай холбоотойгоор ажлын тусгай горимоор ажилласан нь аудитыг гүйцэтгэх үе шатанд анхан шатны баримтуудыг хамруулах, тайлбар тодруулга авах, нотлох баримтуудыг бүрдүүлэх зэрэг горим, сорилыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1. Авлагын данстай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн 365,500.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

###### **1.2. Эрсдэл:**

Тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс санхүүгийн тайланд харилцагч байгууллагуудын тооцоо буруу илэрхийлэгдэх.

###### **1.3. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д ".дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

###### **1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

##### **2. Өглөгийн данстай холбоотой асуудал**

###### **2.1. Илрүүлэлт:**

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор тусгаарлах байруудаар үйлчилж байгаа ААН-үүдтэй ор хоногийн төлбөрийн 201,414.6 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлээгүй байна.

###### **2.2. Эрсдэл:**

Тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс санхүүгийн тайланд харилцагч байгууллагуудын тооцоо буруу илэрхийлэгдэх.

###### **2.3. Өгсөн зөвлөмж:**

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д ".дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

###### **2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.



### **3.Зардлын данстай холбоотой асуудал**

#### **3.1. Илрүүлэлт:**

Тайлант онд сургалт семинар зохион байгуулахад 46,207.6 мянга, урсгал засвар хийхэд 238,525.9 мянга, тавилга эд хогшил худалдан авахад 40,991.5 мянган төгрөг, нийт 325,725.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

#### **3.2. Эрсдэл:**

Холбогдох дээд байгууллагын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлээгүйгээс үргүй зардал гарах.

#### **3.3. Өгсөн зөвлөмж:**

ЗГ-ын 2020 оны 114 дүгээр тогтоолын 3.4-т заасан төсвийн урсгал зардлаас гадаад албан томилолт, сургалт семинар зохион байгуулах, тавилга эд хогшил худалдан авах, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, цалин хөлснөөс бусад бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, бараа үйлчилгээний бусад зардлын санхүүжилтийг зогсоох гэсэн зардлыг санхүүжилтийг түр зогсоох гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

#### **3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **4.Бүтэц зохион байгуулалттай холбоотой асуудал**

#### **4.1. Илрүүлэлт:**

ОБЕГ-ын Ар тал хангалт, хөрөнгө оруулалтын хэлтэст ажиллаж байгаа 9 албан хаагчдын ажлын ачаалал харилцан адилгүй зарим албан хаагчид хэд хэдэн давхар ажил эрхэлдгээс ажлын бүтээмж, хариуцлага сул байна.

#### **4.2. Эрсдэл:**

Ажилчидын ажлын ачааллыг жигдрүүлээгүйгээс ажлын хариуцлага алдагдах.

#### **4.3. Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9 -д "Төсвийн шууд захирагч дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

#### **4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны санхүүгийн аудитын тайлан	Аудитын код:
2020			САГ-2021/337/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	ОБЕГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацаанд оруулбал зохих 173 мэдээллээс хугацаандаа оруулсан 75 мэдээлэл, хугацаа хоцроосон 92 мэдээлэл, 6 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.	0.0	Албан шаардлага	Хангалтын хэлтсийн дарга Мэргэжилтэн	Д.Болорцэцэг Ц.Онон
2	ОБЕГ "Монгол Хьюндай автоматив" ХХК-тай 92,000.0 мянган төгрөгийн санхүүгийн түрээсийн гэрээ байгуулж, Hyundai Sonata DNB /шуурхай алба/-ны автомашиныг холбогдох газрын зөвшөөрөлгүй худалдан авсан байна.	92,000.0	Албан шаардлага	Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч	Я.Гантөмөр Г.Бат-Эрдэнэ
3	Монголын улаан загалмай нийгэмлэгтэй хамтран ажиллах 50,000.0 мянган төгрөгийн сургалт зохион байгуулах нэмэлт гэрээ байгуулж гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй байхад зардлаар тайлагнасан	50,000.0	Албан шаардлага	Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч	Я.Гантөмөр Г.Бат-Эрдэнэ
4	Шадар сайдын 2020 оны 37, 54, 65, 73 дугаар тушаалаар нийт 178,052.2 мянган төгрөгийн зардлыг батлагдсан төсвийн багцаас санхүүжүүлэхээр заасныг зөрчин байгууллага, иргэдийн хандивын хөрөнгөөс зарцуулсан байна.	178,052.2	Албан шаардлага	Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Мэргэжилтэн	Г.Бат-Эрдэнэ Д.Байгалмаа
5	Урьд оны санхүүгийн тайлангийн аудитаар ОБЕГ-ын аппаратын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	0.0	Албан шаардлага	Хяналт шинжилгээ, үнэлгээ, аюулгүй байдлын хэлтсийн дарга Ахлах мэргэжилтэн	Б.Батболд Б.Нямдорж



Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн 365,500.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	365,500.0	Зөвлөмж	Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Мэргэжилтэн	Г.Бат-Эрдэнэ Д.Байгалмаа
7	Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор тусгаарлах байруудаар үйлчилж байгаа ААН-үүдтэй ор хоногийн төлбөрийн 201,414.6 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлээгүй байна.	201,414.6	Зөвлөмж	Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Ахлах мэргэжилтэн	Г.Бат-Эрдэнэ Н.Бадамханд
8	Тайлант онд сургалт семинар зохион байгуулахад 46,207.6 мянга, урсгал засвар хийхэд 238,525.9 мянга, тавилга эд хогшил худалдан авахад 40,991.5 мянган төгрөг, нийт 325,725.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.	325,725.0	Зөвлөмж	Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Ахлах мэргэжилтэн	Г.Бат-Эрдэнэ Ц.Бямбацогт
9	ОБЕГ-ын Ар тал хангалт, хөрөнгө оруулалтын хэлтэст ажиллаж байгаа 9 албан хаагчдын ажлын ачаалал харилцан адилгүй зарим албан хаагчид хэд хэдэн давхар ажил эрхэлдгээс ажлын бүтээмж, хариуцлага сул байна.	0.0	Зөвлөмж	Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч	Я.Гантөмөр Г.Бат-Эрдэнэ
<b>ДҮН</b>		<b>1,212,691.8</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 06 дугаар сарын 25 № 70/А0160059  
СЭГ- 2021 / 337 / СТХ- ПЦЗ  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Урьд оны санхүүгийн тайлангийн аудитаар Онцгой байдлын ерөнхий газрын аппаратын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д заасан “Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- 2.
3. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, аюулгүй байдлын хэлтсийн дарга Б.Батболд, ахлах мэргэжилтэн Б.Нямдорж нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Р.ЦОЛМОН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 71/А0160059

Улаанбаатар хот

САГ-2021/337/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацаанд оруулбал зохих 173 мэдээллээс хугацаандаа оруулсан 75 мэдээлэл, хугацаа хоцроосон 92 мэдээлэл, 6 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан хүлээнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян, Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга Я.Гантөмөр, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Г.Бат-Эрдэнэ нарт даалгав.


**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Р.ЦОЛМОН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 72/40160059  
СЯГ- 2021/337/СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд Онцгой байдлын ерөнхий газар Монголын улаан загалмай нийгэмлэгтэй хамтран ажиллах сургалт зохион байгуулах нэмэлт гэрээ байгуулсан байна. Гэвч дээрх байгууллага сургалт зохион байгуулаагүй байхад тус байгууллагад 50,000.0 мянган төгрөгийг шилжүүлж бусдаар гүйцэтгүүлэх арга хэмжээний зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Онцгой байдлын ерөнхий газар Монголын улаан загалмай нийгэмлэгтэй хамтран ажиллах сургалт зохион байгуулах нэмэлт гэрээгээр олгосон 50,000.0 мянган төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бүртгэж, гэрээний хэрэгжилтийг биелүүлэх, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян, Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга Я.Гантөмөр, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Г.Бат-Эрдэнэ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Р.ЦОЛМОН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 77/АД160059

Улаанбаатар хот

СТА-2021/337/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Онцгой байдлын ерөнхий газар "Монгол Хьюндай автоматив" ХХК-тай 92,000.0 мянган төгрөгийн санхүүгийн түрээсийн гэрээ байгуулж, Hyundai Sonata DNB /шуурхай алба/-ны автомашиныг холбогдох газрын зөвшөөрөлгүй худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7 "төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- 1.Холбогдох газрын зөвшөөрөлгүй, зээлээр үндсэн хөрөнгө бэлтгэж, өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- 2.Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян, Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга Я.Гантөмөр, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Г.Бат-Эрдэнэ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Р.ЦОЛМОН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 78/А0160059

Улаанбаатар хот

СЯГ- 0001/337/СТА- ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шадар сайдын 2020 оны 37, 54, 65, 73 дугаар тушаалаар нийт 178,052.2 мянган төгрөгийн зардлыг батлагдсан төсвийн багцаас санхүүжүүлэхээр заасныг зөрчин байгууллага, иргэдийн хандивын хөрөнгөөс зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян, Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга Я.Гантөмөр, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Г.Бат-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Р.ЦОЛМОН



